

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/117/СТА-ТӨҮГ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	8
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	
	2.11. Шилэн дансны мэдээлэл.....	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
	3.1 Зардалтай холбоотой асуудал.....	10
	3.1.1 Илрүүлэлт:.....	10
	3.1.2 Эрсдэл:.....	10
	3.1.3 Өгсөн зөвлөмж:.....	11
	3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	11
	3.2 Хүүгийн орлогын талаар.....	11
	3.1.2 Илрүүлэлт:.....	12
	3.2.2 Эрсдэл:.....	11
	3.2.3 Өгсөн зөвлөмж:.....	11
	3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
	4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	12
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	13
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	16
	4.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин.....	17
5.	Алдаа зөрчлийн нэгтгэл.....	18



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ХОВД ДУЛААНЫ СТАНЦ”
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ЭНХСАЙХАН ТАНАА

2019.03.20 № 06/524
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Ховд дулааны станц” ТӨХК -ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Ховд дулааны станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Ховд дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Энхсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 15-наас 2019 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн аудитор Г.Энхмаа, аудиторын туслах Б.Жавзансүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 04-ны өдрийн 79 дугаар бүхий албан

бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Ховд дулааны станц” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Тус байгууллага нь Ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэгч байгууллага болох зорилт дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэл:

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: 1450 айл өрх, 56 ААН байгууллага, 23 төсөвт байгууллагын 636 мянган метр куб эзлэхүүнтэй 168 объектыг 17,11 г/кал/ц ачаалалтай дулааны эрчим хүчээр ханган 2 хэлтэс, 6 алба, 102 орон тоотойгоор ажиллаж;

- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаан зохицуулалттай хангах (тусгай зөвшөөрлийн хүрээнд) үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Компанийн тухай хуулийн 84 дүгээр 84.1-д заасны дагуу “Ховд дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж байна.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татвар болон НД-ын багц хуулиуд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Ховд дулааны станц” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материалаг байдлыг суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгосон ба гүйцэтгэлийн үе шатанд зардал нэмэгдсэн тул нийт зардлыг сонгох нь зүйтэй гэж үзлээ.

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлан дахь нийт зардлын дүн нь 546.4 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 10.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав. Материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбараас гадна чанарын үзүүлэлтийг тусгасан болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 зөвлөмж өглөө.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	7.6	
	Дүн	2	7.6	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хөрөнгийн дахин үнэлгээг “Хүлэгтхүннү аудит” ХХК-ийн үнэлгээчин санхүүгийн тайлагналын бодит үнэ цэнийг 7,653.8 сая төгрөг гэж тооцоолж, компанийн газар эзэмших эрх, барилга, байгууламжийн нийт хөрөнгийг үнэлж, дүгнэлт өгсөн болно. Дараагийн аудитаар тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгиж, шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн зорилтот түвшний төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 669 дүгээр тогтоолоор 1,994.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,205.3 сая төгрөгийн зардал гаргахаар батласан. 2018 оны гүйцэтгэлээр 2,084.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, харилцах дансны хүүгийн орлого 3.2 сая төгрөг, бусад орлого 122.1 сая төгрөг байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 2,505.2 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 447.4 сая төгрөг, үйл ажиллагааны бус бусад зардалд 99.0 сая төгрөгийн тус тус зардал гаргаж, нийт 841.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан боловч зорилтот түвшинг батласнаас 338.4 сая төгрөгөөр бууруулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журам батлагдсаны дагуу тус байгууллагын вэб сайтад шилэн дансаа нээж мэдээллүүдээ оруулсан. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл
- Концессийн мэдээлэл
- Худалдан авах ажиллагааны тайлан зэргийг шивж оруулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

Бид “Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Ховд дулааны станц” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Буцалтгүй тусламжийн 2.3 сая, баяр ёслол, арга хэмжээний 3.2 сая, спортын арга хэмжээний 1.8 сая, нийт 7.3 сая төгрөгийг Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт шингээн тооцож зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4 т Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.8.1-д “*Үйлдвэрлэлийн өртгийн бүртгэл нь БМ-ийн бүртгэлийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүний зорилго нь үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдон гарсан шууд болон шууд бус зардлыг үнэн зөв, системтэй тооцоход оршино. Үйлдвэрлэл, үйлчилгээний өртгийг тооцоходоо шат дамжлагын болон ажлын захиалга өртгийн аргыг ашиглана. Үйлдвэрлэл, үйлчилгээний зардлыг: шууд материал, шууд цалин, үйлдвэрлэлийн нэмэгдэл гэсэн бүхий л зардлууд орно*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг зөрчсөн байх, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүд зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмж хүлээн зөвшөөрсөн: Цаашид холбогдох хууль, дүрмийг хэрэгжүүлж ажиллана гэж хариу ирүүлсэн.

3.2 Хүүгийн орлогын талаар

3.2.1 Илрүүлэлт:

Банкны хүүгийн орлого болох 3.2 сая төгрөгийг тусгайлан хувь хэмжээтэй орлогоор тусгаж 0.3 сая төгрөгийн татварыг тооцоогүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2010 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 121 дүгээр тушаалаар батлагдсан Санхүүгийн болон орлогын татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журамтай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг зөрчсөн байх, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүд зөрчигдөх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмж хүлээн зөвшөөрсөн: Цаашид холбогдох хууль, дүрмийг хэрэгжүүлж ажиллана гэж хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10 -ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12,690,715.56	11,121,196.58
1.1.2	Дансны авлага	304,693,735.60	216,124,028.38
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	436,078.81	38,105,622.68
1.1.4	Бусад авлага	2,026,070.60	0.00
1.1.6	Бараа материал	273,267,050.48	656,580,523.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	912,128.00	16,036,300.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	594,025,779.05	937,967,671.37
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,696,514,864.33	12,036,049,771.75
1.2.2	Биет бус хөрөнгө	19,997,222.21	217,981,222.20
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,716,512,086.54	12,254,030,993.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,310,537,865.90	13,191,998,665.32
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	196,964,766.82	317,867,841.00
2.1.1.3	Татварын өр	13,678,385.71	2,006,979.42
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,398,862.00	6,473,333.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	947,079.18	0.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	214,989,093.71	326,348,153.42
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	532,903,225.82
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	532,903,225.82
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	13,285,935,498.23	13,285,935,498.23
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	-111,888,595.92
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	202,150,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-190,386,726.35	-1,043,449,616.23
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-841,662,889.88
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	-190,386,726.35	-201,786,726.08
2.3.11	Эздийн өмчийн дүн	13,095,548,771.88	12,332,747,286.08
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,310,537,865.59	13,191,998,665.32

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	872,188,544.10	2,084,581,212.36
2	Борлуулалтын өртөг	879,809,454.58	2,505,183,608.01
3	Нийт ашиг(алдагдал)	-7,620,910.48	-420,602,395.65
5	Хүүгийн орлого	2,633,228.17	3,240,499.00
8	Бусад орлого	23,494,563.28	122,097,460.25
8.1	Орлогын дүн	26,127,791.45	125,337,959.25
9	Борлуулалт, маркетингийн зардал	15,901,127.74	99,047,586.59
10	Ерөнхий ба удирдлагын зардал	192,992,479.58	447,350,866.89
12.1	Зардлын дүн	208,893,607.32	546,398,453.48
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-190,386,726.35	-841,662,889.88
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-190,386,726.35	-841,662,889.88
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-190,386,726.35	-841,662,889.88

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,980,824,506.00		5,000,000.00	-2,088,769,214.12	13,897,055,291.88
НББ-ын бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				5,000,000.00	5,000,000.00
Залруулсан үлдэгдэл	15,980,824,506.00			-2,083,769,214.12	13,902,055,291.88
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				-806,506,520.00	-806,506,520.00
Өмчид гарсан өөрчлөлт	-2,694,889,007.77		-5,000,000.00	-2,699,889,007.77	0.00
2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	13,285,935,498.23		0.00	-190,386,726.35	13,095,548,771.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-11,400,000.00	-11,400,000.00
Залруулсан үлдэгдэл	13,285,935,498.23			-201,786,726.35	13,084,148,771.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-841,662,889.88	-841,662,889.88
Өмчид гарсан өөрчлөлт			202,150,000		202,150,000.00
Дахин үнэлгээний нэмэгдэл		-111,888,595.92			-111,888,595.92
2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	13,285,935,498.23	-111,888,595.92	202,150,000	-1,043,449,616.23	12,332,747,286.08

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	882,849,919.12	2,482,309,287.97
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	871,518,211.95	2,369,876,739.97
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	6,637,452.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	11,331,707.17	105,795,096.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	840,134,170.12	2,779,262,005.77
1.2.1	Ажиллагчдад төлсөн	270,555,251.62	749,910,403.29
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	85,820,554.00	227,149,189.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	127,679,864.50	496,702,399.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	141,061,707.00	454,462,320.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	117,750,228.00	525,515,825.46
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	28,532,744.14
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	95,096,865.00	287,502,122.98
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	1,178,250.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,169,700.00	8,308,751.90
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	42,715,749.00	-296,952,717.80
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	43,324,202.50	237,520,027.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	31,324,202.50	237,376,027.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,000,000.00	-
2.2.6	Бусад	-	144,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-43,324,202.50	-237,520,027.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	590,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	590,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	57,096,774.18
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	57,096,774.18
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	532,903,225.82
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-608,453.50	-1,569,518.98
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,299,169.06	12,690,715.56
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,690,715.56	11,121,196.58

4.5 Зорилтот түвшин

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл	2018 он		Өөрчлөлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү (3-2)	Хувь (3*100/2)
А	Б	1	2	3	4	5
Нийт орлого:	сая/төг	1,959.9	2,025.2	2,209.9	184.7	109.1
Үүнээс: Цэвэр борлуулалт	сая/төг	1,959.9	2,025.2	2,084.6	59.4	102.9
Нийт зардал:	сая/төг	3,070.4	3,205.3	3,051.6	(153.7)	95.2
Үүнээс: удирдлагын зардал	сая/төг	83.1	100.2	447.3	347.1	446.4
борлуулалт, маркетингийн зардал	сая/төг	15.9	-	99.0	99.0	-
Татварын өмнөх ашиг / алдагдал /	сая/төг	(190.4)	(1,180.1)	(841.7)	338.4	71.3
Цэвэр ашиг / алдагдал /	сая/төг	(190.4)	(1,180.1)	(841.7)	338.4	71.3
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	Төгрөг	1.57	1.58	1.38	(0.20)	12.8
Нийт авлага	сая/төг	308.1	117.1	270.3	153.2	(130.8)
Нийт өр төлбөр	сая/төг	215.0	110.1	859.2	749.1	(680.4)
Үүнээс: Богино хугацаат өр	сая/төг	215.0	110.1	326.3	216.2	(196.4)
Урт хугацаат өр төлбөр	сая/төг	-	-	532.9	532.9	-
Хөрөнгө оруулалт, их засвар	сая/төг	171.5	183.9	183.9	-	-
Ажиллагсдын тоо	хүн /тоо	102.0	102.0	102.0	-	-
Цалингийн сан	сая.төг	809.7	809.7	851.4	41.7	(5.2)

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Ховд дулааны станц”-ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.03.15			САГ-2019/117/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:	“Ховд дулааны станц” ТӨХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Буцалтгүй тусламжийн 2.3 сая, баяр ёслол, арга хэмжээний 3.2 сая, спортын арга хэмжээний 1.8 сая, нийт 7.3 сая төгрөгийг Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт шингээн зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4 т Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.8.1-д “Үйлдвэрлэлийн өртгийн бүртгэл нь БМ-ийн бүртгэлийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүний зорилго нь үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдон гарсан шууд болон шууд бус зардлыг үнэн зөв, системтэй тооцоход оршино. Үйлдвэрлэл, үйлчилгээний өртгийг тооцохдоо шат дамжлагын болон ажлын захиалга өртгийн аргыг ашиглана. Үйлдвэрлэл, үйлчилгээний зардлыг: шууд материал, шууд цалин, үйлдвэрлэлийн нэмэгдэл гэсэн бүхий л зардлууд орно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.	7.3	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхмөрөн

“Ховд дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2	<p>Банкны хүүгийн орлого болох 3.2 сая төгрөгийг тусгайлан хувь хэмжээтэй орлогоор тусгаж 0.3 сая төгрөгийн татварыг тооцоогүй байна.</p> <p>Энэ нь Сангийн сайдын 2010 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 121 дүгээр тушаалаар батлагдсан Санхүүгийн болон орлогын татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журамтай нийцэхгүй байна.</p>	0.3	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхмөрөн
	Нийт дүн	7.6			

